



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 06

Номгон

Өрөмдмөл худгийн эзэмшигч
тогтоох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3а,в, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Эрчим хүчний тухай хуулийн 30.1.13, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Хүрээмарал, Баянбулаг сумуудад хийгдсэн 8 000 064 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн эзэмшигчийг нэгдүгээр, Улсын төсвийн хөрөнгөөр сумуудад хийгдсэн 10 нэрийн 185 522 321 төгрөгийн өртөг бүхий өрөмдмөл худгийн эзэмшигчийг хоёрдугаар хавсралтаар тус тус тогтоож холбогдох байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсүгэй.

2. Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Комисс томилж хөрөнгө хүлээнгэн өгөх, хүлээн авч бүртгэх ажлыг тухайн байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албанд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн
 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн зургаадугаар
 тогтоолын нэгдүгээр хавсралт



БАЙГАЛЬ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛААР
 ХИЙГДСЭН ХӨРӨНГӨД ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүртгэлд тусгах дүн /мян.төг/	Хөрөнгийн эх үүсвэр	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Улсын комисс хүлээн авсан эсэх	Эзэмшигч байгууллага	Тайлбар
1	Хүрээмарал	Холбоогийн булаг	Булгын эх хашсан	м2	144	27 778	4 000 032	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал	БҮДУМА ХХК	авсан	Хүрээмарал сумын ЗДТГ	Булгийн хамгаалалт 48 м урттай, 1,5 м өндөртэй. 20 ширхэг хашаатай цементэн суурьтай
2	Баянбулаг	Улаантолгойн булаг	Булгын эх хашсан	м2	144	27 778	4 000 032		БҮДУМА ХХК	авсан	Баянбулаг сумын ЗДТГ	Булгийн хамгаалалт 48 м урттай, 1,5 м өндөртэй. 20 ширхэг хашаатай цементэн суурьтай
			Нийт дүн		288		8 000 064					

_____ ооо

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн
зургаадугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН
ӨРӨМДМӨЛ ХУДАГТ ЭЗЭМШИГЧ ТОГТООСОН ЖАГСААЛТ

№	Сумын нэр	Худгийн нэр	Координат		Худгийн гүн/м	Үндэрт/л,сек	Статик түвшин	Динамик түвшин	Насос суулах гүн/м	Насос		Мотор		Худгийн нийт үнэ/төг/	Эзэмшигч байгууллагын нэр
			Өргөрөг	Уртраг						Марк	Үнэ/мя н.төг/	Марк	Үнэ/мян.төг/		
1	Жинст	Зүүн хонгор	45.29.04	100.46.37	40	1,2	24	26	32	100QJD	450,0	kamegi	850,0	17823619	ЗДТГ
2	Бөмбөгөр	Дааган дэл	46.11.51	99.49.42	40	1,2	4	8	18	100QJD	450,0	kamegi	850,0	17746006	ЗДТГ
3	Баянговь	Бор хуруу	45.58.24	100.06.59	100	1,2	42	54	60	100QJD	450,0	kamegi	850,0	22346299	ЗДТГ
4	Өлзийт	Бор цохио	16.912	101.12.16	60	1,2	11	32	45	100QJD	450,0	kamegi	850,0	18567805	ЗДТГ
5	Өлзийт	Цагаан дэрс	46.00.20	100.05.25	40	1	3	15	25	100QJD	450,0	kamegi	850,0	17848879	ЗДТГ
6	Өлзийт	Шанд	45.41.19	100.00.20	72	0,5	15	55	65	100QJD	450,0	kamegi	850,0	18166769	ЗДТГ
7	Баацагаан	Нарийн	45.42.33	100.16.48	40	1,2	18	19	25	100QJD	450,0	kamegi	850,0	17955783	ЗДТГ
8	Жинст	Муруй	45.35.01	100.03.26	60	0,8	25	30	45	100QJD	450,0	kamegi	850,0	18216525	ЗДТГ
9	Баянхонгор	Ганц толгой	46.12.42	100.43.01	80	1,2	15	35	45	100QJD	450,0	kamegi	850,0	19202086	Баянхонгор ТОХИЖИЛТ үйлчилгээ ОНӨААТУГ
10	Баацагаан	Талын гүн	45.47.59	98.50.12	60	0,6	8	30	28	100QJD	450,0	kamegi	850,0	17648550	ЗДТГ
														185522321,0	